



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/100

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сар ын 13-ны өдрийн "Журам батлах тухай" А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавьх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зээлийн барьцаа хөрөнгөнд үнэлгээ өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (П.Сольтогтох Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Д.Энхжин (Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Г.Пүрэвдолгор (Халамжийн ажилтан)

Г.Наранхүү (Төрийн банкны эрхлэгч)

Нарийн бичгийн дарга: О.Пүрэвдулам (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

2.Зээлийн барьцааны гэрээнд барьцаалах эд хөрөнгийн үнэлгээг үнэн зөв тогтоож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (П.Сольтогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/10^а

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит 11 дүгээр хуралдааны 07 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын волейболын тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй ангилалаар зохион байгуулж, зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


2.Тэмцээнд зарцуулах 1,560,000 (нэг сая таван зуун жаран мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогчийг түр орлон гүйцэтгэгч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.СУГАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 07 дүгээр сарын 04 ний өдрийн 11/04
дүгээр захирамжийн хавсралт



№	Шагналт байр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Медаль	ш	42	10,000	420,000
2	Өргөмжлөл	ш	6	20,000	120,000
3	1-р байр	ш	2	200,000	400,000
4	2-р байр	ш	2	150,000	300,000
5	3-р байр	ш	2	100,000	200,000
6	Шүүгчийн урамшуулал	ш	2	60,000	120,000
	Дүн				1,560,000



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/102

Нарийнтээл сум

Зээл олгох тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Журам батлах тухай" А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавьх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Сумын хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн "Итгэлт нандин төгс" ХХКомпани Н.Ганбаатар "Хүнсний ногоо, ногоон тэжээл" төсөлд 10,0 сая.төгрөг, "Ганган төгөлдөр" нөхөрлөл Л.Ганбаатар "Хог боловсруулах" төсөлд 14,0 сая төгрөг, "ЭНЖОЙМЕНТ ЛЛТ" хоршоо Ц.Нямдаваа "Нарлаг хүлэмж" төсөлд 10.0 сая.төгрөг, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн Ж.Сангижаргал "Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, ногоон тэжээл тарих" төсөлд 7.0 сая төгрөг, О.Даваадавга "Хэрчсэн гурил" төсөлд 3,0 сая.төгрөг, Т.Мөнхбаатар "Мах сүүний үхэр үржүүлэх" төсөлд 7,0 сая.төгрөг, Т.Наранбаатар "Малын тэжээл тариалах" төсөлд 6,0 сая.төгрөг, Т.Ганболд "Сүү, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй" төсөлд 14,0 сая.төгрөг, Ч.Отгонбаяр "Баялаг хүнс, талх нарийн боов" төсөлд 9,0 сая.төгрөг, Ц.Одгэрэл "Арвин сүрэг" төсөлд 6,0 сая.төгрөг, Ц.Цэвээнсүрэн "Мал нядалгааны цэг байгуулах" төсөлд 58,6 сая төгрөг, Д.Хатанбаатар "Өндөр ургац" төсөлд 7,0 сая.төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хоршоо хөгжүүлэх сангаас олгосугай.

2.Хөнгөлөлттэй зээлэнд хамрагдах дээрх төслүүдийн санхүүжилт болох 151.600,000 сая.төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

3.Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавьж ажиллахыг орон тооны бус зөвлөл (О.Цэрэннадмид)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/103

Нарийнтээл сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. А.Отгонбаярт Улсын аварга шалгаруулах "Жудо бөх"-ийн тэмцээнд явах зардал 300,000 (гурван зуун мянга) төгрөгний дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгт зарцуулах 300,000 (гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/104

Нарийнтээл сум

“Эрүүл сүрэгтэн” батламж олгох туршилтын
хөтөлбөрийн ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь, 59 дүгээр зүйлийн 59.1.11дэхь заалт, мал эмнэлгийн газрын 2023 оны 06-р сарын 30 өдрийн А/21 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд зорилтот өрхийн үхэр сүрэгт батламж олгох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2 Бруцеллёз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах ажлын мэдээллийг малчдад хүргэн, үхэр сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд уг арга хэмжээнд үхэр сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэд, малчдад тус тус үүрэг болгосугай.

3. Зорилтот өрхийн үхэр сүргээс баталгаажуулах шинжилгээг бүрэн авч, шинжлэх ажлыг стандартын дагуу зохион байгуулахыг “Бумбат суварга” МЭҮН-ийн эмч Д.Цэцгээ, малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч Д.Бямбадолгор нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тус ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн Малын эрүүл мэндийг хамгаалахад төсөвлөсөн зардлаас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д даалгасугай.

4.Ажлын тайланг 2023 оны 9 дүгээр сарын 25-ны дотор Мал эмнэлгийн газар хүргүүлэн ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР



622311223

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/104
дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Г.Батсүх (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)
Гишүүд: О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)
Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)
О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)
Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)
Д.Цэцгээ (Малын их эмч)
С.Пүрэвсүрэн (МЭХЦХЦэгийн дарга)
Ц.Мөнхдорж (МЭХЦХЦэгийн ариутгагч)

_____оо_____



Нарийнтээд сумын Засаг даргын
2023 оны 17 дугаар сарын 23-ны өдрийн
А/16/4 захирамжийн 1 дугаар хавсралт

**МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЗАМААР МАЛЧИН ӨРХӨД
“ЭРҮҮЛ СҮРЭГТЭН” ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨР АЖЛЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Сонгогдсон малчин өрхийн мал сүрэгт бруцеллэзын шинжилгээ хийх, шимэгч илрүүлэх, мах сүүнд антибиотикийн үлдэгдэл тодорхойлох замаар “Эрүүл сүрэгтэн” гэрчилгээ олгох туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж сумын түвшинд хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах загвар бий болгох
Төсөл хэрэгжих сум: Нарийнтээл

Бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа

Хугацаа	Хариуцан эзэн	Хамтран хэрэгжүүлэх хийх шинжилгээний
Бүтээгдэхүүн-1: Ажлын ерөнхий төлөвлөгөө болон хувийн мал эмнэлгүүдийн дээж цуглуулах, лабораторийн шинжилгээний нарийвчилсан төлөвлөгөө боловсруулагдсан байна:		
Сумын Засаг даргын захирамж гаргуулж, сумын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хөрөнгө санхүүг шийдвэрлэх	Сумын ЗДТГ, МЭТасаг	МЭҮНэгж
Тандалтад хамрагдах малын тоо, өрхийн судалгааг нарийвчлан гаргах	6-р сарын 20-ний дотор	ЗДТГазар, МЭҮНэгж
Тандалтын ажилд оролцох хүн хүч, хэрэглэгдэхүүн, зардлын тооцоог гаргах	6-р сарын 10-ны дотор	МЭҮНэгж
Сумын түвшинд хийгдэж байгаа бруцеллэзын тандалт шинжилгээний ажлыг зохион байгуулах, зорилтот өрхийг 100% хамруулах, сумын зохион байгуулалтад хяналт тавих	МЭТасаг	МЭҮНэгж,

Бүтээгдэхүүн-2: Хувийн мал эмнэлгүүдэд дээж цуглуулах, лабораторид хийгдэх шинжилгээний арга зүй, шинжилгээний үр дүнг хэрхэн баталгаажуулах талаар сургалт явуулсан байна

Аймгийн мал эмнэлгийн газраас хувийн мал эмнэлгүүдэд дээж цуглуулах, лабораторийн шинжилгээ хийх талаар онол практикийн сургалт хийх	Х.Мөнхцэцэг /Ажлын хэсэг/	Сумдын МЭТасаг, МЭҮНэгж
“Эрүүл сүрэгтэн” батламж олгох туршилтын хөтөлбөрийн	МЭҮНэгж	МЭТасаг

хүрээнд 30 малчинтай МЭҮНэгж гэрээ хийх.					
Дээж цуглуулах цэгийг тодорхойлж, зураглал гаргах	7-р сарын 20-нд	Д.Бямбадолгор	МЭҮНэгж		
МАА-н ЭЗЭН төслөөс тандалтанд хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмжийг хүлээн авч, сумдын МЭҮНэгжүүдэд хүлээлгэн өгөх	7-р сарын 25-ны дотор	МАА-н ЭЗЭН	МЭҮНэгж	МЭГазар, МЭТасаг, МЭҮНэгж	
Бруцеллэцийн тандалт шинжилгээнд дээж авах	7 сарын дугаар 28, 8 дугаар сарын 10, 8 дугаар сарын 28	МЭҮНэгж	МЭТасаг		
МЭҮНэгжүүд сумын зорилтот өрхөөс сүүний дээж цуглуулж, сүүний дээжинд шинжилгээ хийх /3 удаа/					
Бүтээгдэхүүн3: Лабораторийн шинжилгээгээр эрүүл гарсан өрхүүдэд “Эрүүл сүрэгтэн” гэрчилгээ олгосон байна					
Сүүний цагирган урвалаар эерэг гарсан өрхийн үхэр сүргээс ийлдсийн дээж цуглуулах	7,8,9 дүгээр сарын 10-ны дотор	МЭТ, МЭҮНэгж	МЭГазар		
Сүүний цагирган урвалаар сөрөг гарсан өрхийн үхэр сүргийг ийлдсийн дээж авч, баталгаажуулах шинжилгээ хийх /түүвэрчилж/	7,8,9 дүгээр сарын 10-ны дотор	МЭТ, МЭҮНэгж	МЭГазар		
Туршилтын хөтөлбөрт оролцсон малчин тус бүрийн шимэгч өвчний нөхцөл байдлыг тодорхойлох	7,8,9 дүгээр сарын 10-ны дотор	МЭҮНэгж	МЭТасаг		
Дээж авсан цэг тус бүрийн малчин болон малын мэдээллийг бүртгэх, системд оруулах	7,8,9 дүгээр сарын 10-ны дотор	МЭТ, МЭҮНэгж	МЭГазар		
Сүүний шинжилгээгээр Эерэг, сөрөг гарсан өрхийн үхрийн ийлдсийн дээжинд аймаг РБУрвал, УлсадELISSA, ХХУ, НТУрвалаар баталгаажуулах шинжилгээ хийх	7,8,9-р сарын 10-ны дотор	Х.Мөнхцэцэг, МЭҮНэгж	Лабораторийн эмч нар, УМЭАЦЛаборатори, МЭХүрээлэн		
Сүүний цагирган урвалын 3 удаагийн шинжилгээгээр эрүүл болох нь батлагдсан малчин өрхүүдэд “Эрүүл сүрэгтэн” эрчилгээ олгох	9-р сарын 30-ны дотор	А.Энхтүвшин Х.Мөнхцэцэг	МЭТасаг		
Бүтээгдэхүүн 4: Мал сүрэг нь шинжилгээгээр эерэг гарсан малчин өрхийн гишүүдийг бруцеллэцийн шинжилгээнд хамруулсан байна					
Мал сүрэг нь бруцеллэцоор халдвартай гарсан малчдад мэдээлэл хүргэх.	Тухай бүр	Сумдын МЭТасаг, ЭМТөв	МЭҮНэгж		
Малчдыг бруцеллэцийн шинжилгээнд хамруулах	7-р сарын 25-аас 9-р сарын 01-ны хооронд	ЭМТөв	ЗДТГазар, МЭТасаг		

Шинжилгээний үр дүнг тайлагнах	9-р сарын 20 -ны дотор	ЭМТөв	ЗДТГазар, МЭТасаг
Бүтээгдэхүүн 5: Малаас хүнд халдварладаг өвчнөөс сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахад малчдыг үүрэг оролцооны талаар сургалт зохион байгуулсан байна			
Бруцеллээс өвчин нь малаас хүнд халдварладаг тухай мэдээлэл бүхий гарын авлага, зохистой дадал хэвшүүлэх гарын авлагыг малчдад тараах	7 дугаар сарын 28	МЭТасаг	МЭҮНэгж
Сүүний цагираган урвалаар эерэг гарсан малтай айлуудын малчдад хөдөө аж ахуйн сайн дадлын сургалтыг сум бүр 2 удаа зохион байгуулах	8 дугаар сарын 10	МЭТасаг	МЭГазар
Тандалт шинжилгээ болон хийгдсэн ажлын мэдээллийн олон нийтийн сүлжээ болон сумын веб сайтад мэдээлэх, сурталчилах	Жилдээ	МЭГазар	МЭТасаг
Бүтээгдэхүүн 6: Үр дүн, олж илрүүлсэн зүйлс, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан боловсруулсан байна			
Сумдын МЭТасгууд тандалт шинжилгээний явцын мэдээ болон эхний тайланг төсөлд хүргүүлэх.	7-р сарын 10-ны дотор	МЭТасаг	МЭҮНэгж
Шинжилгээний үр дүнг багтаасан дэлгэрэнгүй тайлан бичих, Энэхүү тайланг санхүүгийн тайлангийн хамт МААЭЗЭНТ-д хүлээлгэн өгөх	9-р сарын 30-ны дотор	Х.Мөнхцэцэг	Ажлын хэсэг
Нэгдсэн дүгнэлт гаргах, семинар зохион байгуулах.	10-р сарын 10-ны дотор	МАА-н ЭЗЭН төсөл, МЭЕГазар	МЭГазар, МЭТ

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

МАЛ ЭМНЭЛГИЙН ТАСГИЙН ДАРГА  Д.БЯМБАДОЛГОР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А1105

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. "Залуучуудын волейбол"-ын тэмцээн зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсагуй.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Сайнбилэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүд: Ч.Оюунзул (Архив бичин хэргийн ажилтан)

Г.Пүрэвдолгор (Хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)

Э.Мөнхбат (Нярав)

А.Батмөнх (Засаг даргын Тамгын газрын жолооч)

Г.Наранхүү (Төрийн банкны эрхлэгч)

М.Мөнхбаатар (Иргэн)

Д.Дашзэвгэ (Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа)

Б.Чимэд-Очир (Олон нийтийн цагдаа)

Н.Нямсүрэн (Нийгмийн даатгалын байцаагч)


2. Тус тэмцээнийг чанартай зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Сайнбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 04 дугаар сарын 06 ны өдрийн А/106
дугаар захирамжийн хавсралт



БАЯР НААДМЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Морины бай				4,620.000
2	Бөхийн бай				970.000
3	Сурын бай				390.000
4	Шагайн бай				500.000
5	Өргөмжлөл, медаль	ш			2,020.000
7	Цагаан идээ	Кг			1,980.000
8	Засуулын урамшуулал				160.000
9	Бусад				360.000
	ДҮН				11,000.000

_____ ооо _____



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/106

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум байгуулагдсаны 92 жилийн ойн баяр наадмын уралдаан тэмцээнд 11,000.000 (арван нэгэн сая) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх 11,000.000 төгрөгийг Засаг даргын Тамгын газрын баяр наадмын зардлаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622311228



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/107

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум байгуулагдсаны 92 жилийн ойн баяр наадмын уралдаан тэмцээнд 2,611.800 (хоёр сая зургаан зуун арван нэгэн мянга найман зуун) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх 2,611.800 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 07 дугаар сарын 06 ны өдрийн А.1107
дугаар захирамжийн хавсралт



БАЯР НААДМЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Шатахуун				611.800
2	Хонь	ш	1	250.000	250.000
3	Баяр наадмын комиссын хоолны зардал				1,470.000
4	Бусад				80.000
5	Нээлтийн арга хэмжээний зардал				200.000
	ДҮН				2.611.800

_____ ооо _____



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/108

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Эрүүл мэндийн төвийн хог шатаах зуух" худалдан авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:Г.Билгүүн (Баянтээг багийн Хүн эмнэлгийн эмчлэгч их эмч)

Гишүүд:Ж.Шижирбаатар (Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч)

С.Цогзолмаа (Баянтээг багийн Хүн эмнэлгийн нярав)

М.Энх-Амгалан (Баянтээг багийн Хүн эмнэлгийн сувилагч)

Нарийн бичгийн дарга:Г.Лхагвадолгор (Баянтээг багийн Хүн эмнэлгийн статистик мэдээллийн ажилтан)

2.Бараа худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмын дагуу ажиллаж чанарын шаардлага хангасан бараа нийлүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Г.Билгүүн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/109

Нарийнтээл сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Баянтээг багийн Гэрэлтүүлэгийн өргөтгөл засварын ажлыг" гүйцэтгэх тендер шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: С.Баасандулам (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: А.Баасандолгор (Дотуур байрны багш)

Б.Сосорбурам (Бага ангийн багш)

Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ц.Сайнбилэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2."Баянтээг багийн Гэрэлтүүлэгийн өргөтгөл засварын ажлыг" гүйцэтгэх тендерийн техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах, нээх, хаах, тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (С.Баасандулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

№ 622311233



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/110

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Ерөнхий боловсролын сургуулийн сантехникийн засварын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Гандолгор (Бага ангийн сургалтын менежер)

Гишүүд: О.Энх-Амгалан (Ерөнхий боловсролын сургуулийн нярав)

А.Баасандолгор (Дотуур байрны багш)

Б.Төмөрбаатар (Ерөнхий боловсролын сургуулийн жижүүр)

Нарийн бичгийн дарга: Б.Сосорбурам (Бага ангийн багш)

2.Сантехникийн засварын ажлын тендерийн техникийн тодорхойлолт бэлтгэх, урилга, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах, нээх, хаах, тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Гандолгор)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622311235



ӨВӨРХАНГАЙ ЛЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/111

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Шарга багийн төвийн тохижилтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд: Ч.Даваадорж (Иргэн)

Г.Ууганбаяр (Иргэн)

Г.Ариунжаргал (Хаан банкны эрхлэгч)

Нарийн бичгийн дарга:Ц.Цэвээнсүрэн (Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны мэргэжилтэн)

2.Шарга багийн төвийн тохижилтын ажлын техникийн тодорхойлолт бэлтгэх, урилга, тендерийн баримт бичиг боловсруулах, хүлээн авах, нээх, хаах, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (О.Цэрэннадмид)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/МЧ

Нарийнтээл сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өндөр-хөмөг багт зохион байгуулах өдөрлөгийн арга хэмжээнд зориулан 500,000 (таван зуун мянга) төгрөгний дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгт зарцуулах 500,000 (таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/МС.

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2023 оны төсөв батлах тухай" 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 13 дүгээр хуралдааны 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Тус суманд "Эрүүл сүрэгтэн" хөтөлбөрийг ард иргэдэд сурталчлан таниулах сургалт, уулзалтыг зохион байгуулах зардалд 410.000 (дөрвөн зуун арван мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх 410,000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны ... дугаар сарын ... ний өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Хоол	ш	30	10.000	300.000
2	Цай /халуун сав/	ш	4	3.500	14.000
Дүн					314.000
Үдийн цайнд					
1	Кофе	ш	30	700	21.000
2	Кейкс	ш	30	2.500	75.000
Дүн					96.000
Нийт					410.000

_____ ооо _____



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/129/

Нарийнтээл сум

Комисс томилох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрийн бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлж, бэлчээрийн даацыг тодорхойлох комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Н.Мягмаржав (Газрын даамал)

Гишүүдэд: Г.Наранбаатар (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Хорлоо (Цаг уурч)

О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)

О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)

Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)

2.Бэлчээрийн даацыг тодорхойлон 2023 оны 08 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг комиссын дарга (Н.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622311259



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/123

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн "Журам батлах тухай" 296 дугаар тогтоолоор баталсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1.4, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4, дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Баянтээг багийн нутаг дэвсгэр дээр явагдах бичил уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ичинноров (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Г.Наранбаатар (Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Л.Батнаран (Экологийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

О.Пүрэвдулам (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

Н.Мягмаржав (Газрын даамал)

2.Бичил уурхайн үйл ажиллагаанд хяналт тавьж ажлын тайланг сумын Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ичинноров)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/124

Нарийнтээл сум

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төлд бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн чанартай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "Бумбат суварга", "Бумбат-Ур" хувийн мал эмнэлгийн эмч нарт үүрэг болгосугай.

2. Вакцинжуулалтын төлөвлөлтийг хийж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нартай хамтарч ажиллахыг Тархвар зүйч (П.Төмөртоогоо)-д даалгасугай.

3.Багийн малчид иргэдэд дархлаажуулалтын ажлын зар, мэдээллийг цаг тухайд нь хүргэж, хариуцсан багийн мал сүргийг тогтоосон хугацаанд бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, дархлаажуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тарилгын акт, жагсаалт тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

G22311263